



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.10.29 № 013/139

**Зөрчлийг арилгуулах тухай**

Монгол Улсаас Сингапур улсад суугаа Элчин сайдын яамны 2012 он, 2013 оны 1-9 сарын санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад дараахь зөрчил илэрлээ.

2013 оны эхний 9 сарын байдлаар үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогоор 37.5 мянган ам.доллар оруулах төлөвлөгөөтэй ажиллаж, 58.6 мянган ам.доллорын орлого олж, орлогын төлөвлөгөөг 56,3 хувиар давуулж биелүүлсэн байна. Үүнээс 12.7 мянган ам.долларын орлогыг тайлан бүртгэлд тусгалгүйгээр шагнал урамшуулалд зарцуулж, 45.9 мянган ам.долларын орлогыг тайлан бүртгэлд тусгасан ч улсын төсөвт төвлөрүүлэлгүй үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасан "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулахын тулд акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэсэн заалтыг үндэслэн дээрх зөрчлийг арилгах албан шаардлагыг өгч байна.

Дээрх 12.7 мянган ам. долларын орлогыг 2013 оны жилийн эцсийн тайлан тэнцэлд тусгаж, 45.9 мянган ам. долларын орлогыг 2013 оны 12 сарын 20 гэхэд улсын төсөвт төвлөрүүлэн, биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Б.Дэлгэрмаа, нягтлан бодогч Ц.Уранцэцэг нарт даалгав.

АУДИТОР  Ш.ИЧИНХОРЛОО

УХА0122

070432